Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны ...01... дугээр сарын ...02... ны өдрийн 02/05 дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

"НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ" ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2021, 2022, 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2023 оны 12 дугаар сарын 27 Улаанбаатар хот

| д/д | № | Бодлогын зорилго, зорилт арга хэмжээ | Төсөв /сая төг/ | | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Тайлбар (Хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар) | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төсөвлөсөн | Гүйцэтгэл | | Он | Түвшин | Он | Түвшин | | | | |
| Зорилт 3.5. Биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | | |
| 1 | 3.5.1 | Нийслэлийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний чанар сайжирсан байна. | 0 | 0 | Биеийн тамирын арга зүйч | 2019 | 0 | 2023 | Биеийн тамирын 16 арга зүйчтэй болсон байна. | Анхан шатны нэгжид биеийн тамир, спортын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах саналыг Биеийн тамир, спортын улсын хороонд 2021 оны 2/73 албан тоотоор, 2022 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэст тус тус 3/235 албан тоотоор, 2023 онд Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороонд 3/225 албан тоотоор, Биеийн тамир, спортын улсын хороонд 3/225 албан тоотоор тус тус хүргүүлсэн. Дээрх санал Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн байна.<br>Тухайн санал "Биеийн тамир, спортын тухай хууль"-д тусгагдсанаар нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх боломж нээгдэнэ.<br>Үр дүн: Анхан шатны нэгжид биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх нөхцөлийг сайжруулах чиглэлээр санал санаачилга гарган хороодод орон тооны арга зүйч ажиллуулах заалт "Биеийн тамир, спортын тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн байна. | 90% | Биеийн тамир, спортын тухай хуульд орон тооны арга зүйч ажиллуулах заалт тусгуулж батлуулснаар тус ажил хэрэгжинэ. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь манай байгууллагын чиг үүрэг биш болно. | НБТСГ |
| 2 | | | 0 | 0 | Магадлан итгэмжлэгдсэн спорт клуб | 2019 | 11 | 2023 | 25 | Спорт клубүүдийг магадлан итгэмжлэлд хамрагдах зөвшөөрлийг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос олгодог. Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороод спорт клубүүдийг сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлэлд хамрагдах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч магадлан итгэмжлэлд ороход бэлэн болсон материалуудыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлж ажилладаг. Энэ хүрээнд 2021 онд 2 спорт клуб магадлан итгэмжлэгдэж нийт 13 спорт клуб болсон.<br>2022 онд Налайх дүүргийн "Налайх спиннинг" клуб, Сонгинохайрхан дүүргийн "Бумба од" фитнес клубийн материалыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн.<br>2023 онд 6 спорт клубт арга зүйн зөвлөгөө өгч магадлан итгэмжлэлд орох материалыг бэлтгээд байна.<br>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны А/178, А/144 дүгээр тушаалаар батлагдсан Спортын клубийн магадлан итгэмжлэх журмын холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тулгарсан тул Биеийн тамир, спортын салбарт эрхэлсэн сайдын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооноос боловсруулж батлуулах ажлыг хийж байна.<br>Үр дүн: Стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллаж иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 20219 оноос хойш 2 спорт клуб магадлан итгэмжлэгдэж нийт 13 спорт клуб болоод байна. Энэ ажлыг үргэлжлүүлж 2022 онд 2 спорт клуб, 2023 онд 10 спорт клубийг магадлан итгэмжлэлд оруулах материал бэлтгэгдсэн. | 90% | Магадлан итгэмжлэлд сайн дурын үндсэн дээр хамрагдах хуулийн заалттай. Магадлан итгэмжлэх ажлыг Биеийн тамир, спортын улсын хороо хийдэг. Нийслэл, дүүргийн Биеийн тамир спортын хороод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг. | НБТСГ |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | | | 0 | 0 | Иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт | 2019 | 53 | 2023 | 57 | 2021 онд Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын тархалттай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажил зохион байгуулагдаагүй бол 2022 оны 04 дүгээр сарын 01-ээс эхлэн сорил авах ажлыг эхлүүлж нийслэлийн хэмжээнд урьдчилсан байдлаар 87,356 иргэн хамрагдан нийт хамрагдсан иргэдийн 60 хувь нь А, В, С үнэлгээ авсан үзүүлэлттэй байна.<br>2023 онд 175,500 иргэн хамрагдсанаас 82 хувь нь А, В, С үнэлгээ авсан үзүүлэлттэй байна.<br>Засгийн газрын тохируулагч агентлаг - Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан иргэдийн дундах хөдөлгөөний хомсдолоос үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга замыг сайжруулах, нотолгоог бий болгох, иргэдэд зориулсан дасгалын жишиг загварыг боловсруулах ажлын хүрээнд зохион байгуулагдсан арга зүйн сургалтад нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороодын 13 ажилтан, албан хаагч хамрагдаж "Иргэдийн бие бялдрын ерөнхий хөгжил, хөдөлгөөний идэвхийг тодорхойлох" судалгааг 2023 оны 11 дүгээр сарын 13-24-ний өдрүүдэд нийслэлийн хүн амын 18-64 насны 2250 иргэнийг хамруулж асуулга, бие махбодын хэмжилт, бие бялдын сорил гэсэн 3 хэсгээс бүрдсэн мэдээллийг цуглуулан, үр дүнг https://drive.google.com-оор нэгтгэж Засгийн газрын тохируулагч агентлаг - Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн.<br>Үр дүн: Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 2019 онд нийт хамрагдсан иргэдээс 53 хувь нь А, В, С үнэлгээг авч байсан бол 2023 онд 175,500 иргэн хамрагдсанаас 82 хувь нь А, В, С үнэлгээ авч 29 хувиар өссөн сайн үр дүн гарсан байна. | 100% | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг жил бүр зохион байгуулдаг. | НБТСГ |
| 4 | 3.5.2 | Дүүрэг, хороод болон шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд биеийн тамир, спортын барилга байгууламжийг норм, стандартын дагуу барьж байгуулсан байна. | 0 | 0 | Төрөлжсөн спортын талбай | 2019 | 94 | 2023 | 104 | Стандарт шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын талбайг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн орон сууц, гэр хорооллын дунд 3*3 сагсан бөмбөгийн 7 талбайг шинээр байгуулсан бол Чингэлтэй дүүргийн 24 -р сургуулийн гадна талбайг иж бүрэн шинэлчилсэн.<br>2022 онд Хан-Уул дүүргийн 8-р хороонд Хөл бөмбөгийн талбай бүхий техникийн төв тус тус шинээр байгуулагдсан. Сүхбаатар дүүргийн 2-р сургууль, Хан-Уул дүүргийн 34, 52-р сургуулиудын гаднах талбайг спортын төрөлжсөн талбай болгон тохижуулсан. 2023 онд Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 57-р сургууль, Сонгинохайрхан дүүргийн 67-р сургуулийн спорт талбайг хөл бөмбөгийн стандарт хиймэл зүлэг тавьж шинэчлэн тохижуулж дуусгасан. Мөн 37 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулагдаж нийт 141 талбайтай болоод байна.<br>**Үр дүн:** Спортын төрөлжсөн талбайг 44-өөр нэмэгдүүлж 141 болгосон. Мөн 6 сургуулийн спортын талбайг иж бүрэн шинэчилсэн байна. | 100% | 2023 онд 34 байршилд стандарт шаардлагад нийцсэн 3х3 сагсан бөмбөгийн талбайг тохижуулах ажлыг Нийслэлийн Хот тохижуулах газраас хийсэн. | НБТСГ |
| 5 | | | Улсын төсвөөс 17,803,000,000 | Улсын төсвөөс 17,802,700,000 | Спортын барилга байгууламжийн хүртээмж | 2019 | 60 | 2023 | 63 | Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэн 2021 онд Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор, Хан-Уул дүүрэгт битүү дээвэртэй өвлийн спортын ордон, Баянгол дүүргийн 4-р сургуулийн спорт заал, Багануур дүүргийн 1 хороонд спорт заал, Баянгол дүүргийн 20 дугаар сургуульд усан бассейн шинээр ашиглалтад орсон бол 2022 онд Баянгол дүүргийн 15-р хороо хороонд 650 хүний суудалтай спорт цогцолбор, 3-р хороонд "Gan sports center", "UG Arena" спорт цогцолбор, Баянзүрх дүүргийн 26-р хороонд Чухаг спорт төв тус тус ашиглалтад орсон.<br>Мөн 2023 онд Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд Наадам спорт клуб, 2-р хороо Говийн зам дагуу В3 NBA спорт заал, 3-р хороонд Emart спорт заал, Сүхбаатар дүүргийн 11-р хороонд Shine sport center спорт заал, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд "ОБ" спорт заал, 4 дүгээр хороонд Толгойт хөгжлийн төвийн 1 давхарт спорт заал, 29-р хороонд "City" спорт заал тус бүр ашиглалтад орсон. Улсын төсвөөр баригдаж байгаа Налайх дүүргийн спорт цогцолбор 95 хувьтай, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор 85 хувьтай, Сүхбаатар дүүргийн спорт цогцолбор 40 хувьтай, Нийслэлийн Спорт цогцолбор 50 хувьтай, Багахангай дүүргийн спорт цогцолбор 60 хувьтай, Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 50 хувьтай үргэлжилж байна.<br>**Үр дүн:** Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмж 2019 онд 60 мкв байсан бол 2023 онд 3.5 мкв-аар нэмэгдүүлж 63.5 мкв болсон. | 100% | Спортын барилга байгууламжийн хүртээмжийг "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм, БНбД 30-01-04-ийн дагуу спортын заалны шалны талбайн хэмжээг 1000 хүнд харьцуулан тооцдог. | НБТСГ |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 3.5.3 | Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар оролцоог нэмэгдүүлсэн байна. | Улсын төсвөөс 106,430,782 Нийслэ-лийн төсвөөс 1,170,000,000 | Улсын төсвөөс 106,430,782 Нийслэлийн төсвөөс 1,164,571,000 | Нийт хүн амд биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдсан иргэн | 2019 | 725,196 | 2023 | 830,080 | Олон нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээнд өргөнөөр хамруулах зорилгоор 2021 онд Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтаас шалтгаалан 6 арга хэмжээ, 13 удаагийн цахим сугалтыг зохион байгуулж 89,449 иргэнд хүргэж ажилласан бол нийслэл дүүргийн хэмжээнд 116 арга хэмжээг цахим болон практик хэлбэрээр зохион байгуулж 2876 байгууллагын 635.486 иргэнийг хамруулсан.<br>2022 онд 14 арга хэмжээ зохион байгуулж 9407 байгууллагын 423,511 иргэнийг хамруулсан.<br>2023 онд нийтийг хамарсан 24 арга хэмжээ ("Цасны баяр", "Өвлийн спортын наадам", "СӨБ", "ЕБС"-ийн багш, арга зүйчдийн бэлц сургалт, " "СӨБ", "ЕБС"-ийн уран хөдөлгөөнт гимнастик", "Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн биеийн тамирын өдөрлөг", "Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлт, "Алхацгаая гүйцгээе" хөдөлгөөн, "Иргэдийн спортын наадам"-ын явган алхалт, "Нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдын спортын наадам"-ын явган алхалт, "Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил", Нийслэлийн Иргэдийн спортын наадам, Нутгийн захиргааны наадам гэх мэт) зохион байгуулж 2481 байгууллагын 416,000 иргэнийг хамруулсан бол нийслэл, дүүргийн хэмжээнд 368 арга хэмжээнд 9930 байгууллагын 873,313 иргэдийг хамруулсан.<br>Үр дүн: Нийслэлийн иргэдийн дунд нийтийг хамарсан арга хэмжээ, ажил үйлчилгээнд 2019 онд 756,451 иргэдийг хамруулж байсан бол 2023 онд нийслэлийн хэмжээнд 368 арга хэмжээнд 9930 байгууллагын 873,313 иргэдийг хамруулж хамрагдагчдын тоог 116,862-оор нэмэгдүүлсэн байна. | 100% | Нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагаанд зориулж улсын төсвөөс 2021 онд 6570000, (2022 онд төсөв тусгагдаагүй) 2023 онд 99860782 төгрөг нийт 106430782 төгрөгийг зарцуулсан.<br>Нийслэлийн төсвөөс 2021 онд 48198000, 2022 онд 551636000, 2023 онд 564737000 төгрөг нийт 1164571000 төгрөгийг зарцуулсан. | НБТСГ |
| 7 | 3.5.4 | Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэдэг болсон байна. | Улсын төсвөөс 146,782,300 Нийслэ-лийн төсвөөс 270,000,000 | Улсын төсвөөс 145,831,300 Нийслэ-лийн төсвөөс 262,091,000 | Тэмцээнд оролцсон тамирчид | 2019 | 152,096 | 2023 | 152,340 | Спортын тэмцээн уралдааныг 2021 онд нийт 23 удаа зохион байгуулж 518 байгууллагын 27419 хүнийг хамируулсан. Үүнд: Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 2021 онд спортын 22 төрлөөр зохион байгуулж 518 байгууллагын 7086 тамирчид оролцсон.<br>Спортын тэмцээн уралдааныг 2022 онд 19 төрлөөр зохион байгуулж 804 байгууллагын 133102 тамирчдыг оролцуулсан байна.<br>Үүнд: Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 2022 онд спортын 15 төрлөөр зохион байгуулж 446 байгууллагын 7888 тамирчид оролцсон бол багийн спортын төрлөөр 2022 онд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Улаанбаатар лиг" сагсан бөмбөг, волейболын тэмцээн, иргэдийн дунд "UB CUP" "Нийтийн хөл бөмбөгийн фестиваль" зохион байгуулж 358 байгууллагын 125,214 хүүхэд, багачууд, тамирчин, иргэдийг хамруулсан.<br>Спортын тэмцээн уралдааныг 2023 онд 38 төрлөөр зохион байгуулж 673 байгууллагын 153317 тамирчдыг оролцуулсан байна.<br>Үүнд: Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 2023 онд спортын 30 төрлөөр зохион байгуулж 375 байгууллагын 7967 тамирчид оролцсон.2023 онд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн тэмцээн, "Улаанбаатар цом" хөл бөмбөгийн тэмцээн, "Улаанбаатар лиг" волейболын тэмцээн, Монголын хүүхдийн спортын VII наадмын нийслэлийн бүсийн тэмцээнийг багийн спортын 5 төрлөөр тус тус зохион байгуулж 298 байгууллагын 145,350 хүүхэд, багачууд, тамирчид хамрагдсан.<br>Үр дүн: Спортын тэмцээнд 2019 онд 152096 хүүхэд, багачууд, тамирчид хамрагдаж байсан бол 2023 онд хүрэх түвшинд бүрэн хүрч 153317 хүн болж 1221 хүнээр нэмэгдсэн байна. | 100% | Спортын уралдаан, тэмцээнд зориулж улсын төсвөөс 2021 онд 27430000, 2022 онд 15000000, 2023 онд 107000000 төгрөг нийт 145831300 төгрөгийг зарцуулсан.<br>Нийслэлийн төсвөөс 2021 онд 10000000, 2022 онд 152167000, 2023 онд 99924000 төгрөг нийт 262,091,000 төгрөгийг зарцуулсан. | НБТСГ |
| 8 | | | 0 | 0 | Өсвөрийн шигшээ багуудын спортын төрөл | 2019 | 22 | 2023 | 24 | Дүүргийн Засаг даргын дэргэдэх спортын шигшээ багийн төрөлд: 2021 онд спортын 24 төрлөөр 82 дасгалжуулагч, 1814 тамирчин хамрагдсан. 2022 онд спортын 3 төрөл (крикет, хоккей, усан спорт) өөр нэмэгдүүлж 25 төрлөөр 65 багт 101 дасгалжуулагч, 2856 тамирчин хамрагдсан. 2023 онд 9 дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг спортын 28 төрлөөр 105 дасгалжуулагч 2944 тамирчдын бүрэлдэхүүнтэйгээр бэлтгэл, сургуулилт, дасгалжуулалтад хамруулсан. Өсвөрийн шигшээ багийн тамирчид тив, дэлхий, олон улс, хот, нэрэмжит 484 тэмцээнд оролцож 1833 медаль хүртсэн амжилт гаргасан байна.<br>Үр дүн: Тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх зорилгоор өсвөрийн шигшээ багийг 2019 онд 22 спортын төрлөөр байгуулж сургалт дасгалжуулалт явуулж байсан бол 2023 онд спортын 28 төрөл болгон өргөжүүлж суурь түвшнээс 6 төрлөөр нэмэгдүүлж үйл ажиллагааг жигдрүүлж бэлтгэл сургуулилт, дасгалжуулалтад хамруулж байна. | 100% | Өсвөрийн шигшээ багуудад Дүүргүүдийн Засаг даргын нөөцөөс тодорхой хэмжээний санхүүжилтийг авч үйл ажиллагаагаа явуулдаг. | НБТСГ |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | 3.5.5 | Нийслэл Улаанбаатар хотноо олон улсын спортын наадмыг зохион байгуулж дэлхийд сурталчлан таниулах ажлыг шат дараатай зохион байгуулсан байна. | Улс, нийслэл, бусад 18,000,0 | Улсын төсөв 10,600.0 Нийслэ-лийн төсөв 6,800.0 | Улаанбаа-тар хотноо зохион байгуулж буй Олон улсын спортын наадам | 2019 | 0 | 2023 | 1 | "Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа 11 спортын 12 төрлөөр 2023 оны 08 дугаар сарын 16-наас 23-ны өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгууллаа.<br>Тус наадмын бэлтгэл ажлын 30%-ийг 2021 онд, 70 хувийг 2022 онд, 2023 онд 100% хангаж ажилласан.<br>Зүүн Азийн олимпын хороо нь есөн үндэсний олимпын хороог өөртөө нэгтгэдэг бөгөөд энэ удаагийн наадамд долоон үндэсний олимпын хорооны 880 тамирчин 8 өдрийн турш ур чадвар, авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс БНХАУ-ын баг, тамирчид 38 алт, 32 мөнгө, 19 хүрэл медаль авч багийн дүнгээр тэргүүлсэн бол Япон улс 22 алт, 7 мөнгө, 13 хүрэл, БНСУ 11 алт, 21 мөнгө, 24 хүрэл, Хятадын Тайвань 11 алт, 10 мөнгө, 21 хүрэл, Монгол улс 3 алт, 13 мөнгө, 28 хүрэл, Хятадын Хонконг 3 алт, 5 мөнгө, 12 хүрэл авсан амжилт үзүүлсэн байна.<br>"Улаанбаатар-2023" Зүүн Азийн Залуучуудын наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг спорт, ёслолын ажиллагаа, наадмын байгууламжууд, байр, сууц, ажиллах хүч, хангамж, тээвэр, мэдээлэл технологи, хэвлэл мэдээлэл, олон улсын харилцаа, протокол, баталгаажилт, бүртгэл, аюулгүй байдал, олон нийттэй харилцах, маркетинг гэсэн 15 чиглэлд хуваан бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллаж амжилттай зохион байгууллаа.<br>Үр дүн: "Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа зохион байгууллаа. | 100% | "Улаанбаатар 2023" Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх зохион байгуулах хорооноос төсвийг албан ёсоор тайлагнах үүрэгтэй. | НБТСГ |
| Хэрэгжилтийн дундаж | | | | | | | | | | | | | 98.6% |

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБОЛД

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.БЯМБАСАЙХАН

НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР ТУССАН ЗОРИЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2021, 2022, 2023 ОНЫ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 28 Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Батлагдсан төсөв (сая төгрөг) | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) өссөн дүнгээр | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Гүйцэтгэлийн хувь | Үнэлгээний тайлбар | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3. ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА | | | | | | | | | | |
| 1 | 3.5. Биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 3.5.1. Нийслэлийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний чанар сайжирсан байна. | 2021 - 2025 | 0 | 0 | Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн 57 хувь нь A, B, C үнэлгээ авсан байна. | 2021 онд Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын тархалттай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажил зохион байгуулагдаагүй бол 2022 оны 87,356 иргэдийн 60 хувь нь A, B, C үнэлгээ авсан үзүүлэлттэй байна.<br>2023 онд 175,500 иргэн хамрагдсанаас 82 хувь нь A, B, C үнэлгээ авсан үзүүлэлттэй байна.<br>Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 2019 онд нийт хамрагдсан иргэдээс 53 хувь нь A, B, C үнэлгээг авч байсан бол 2023 онд 175,500 иргэн хамрагдсанаас 82 хувь нь A, B, C үнэлгээ авч 29 хувиар өссөн сайн үр дүн гарсан байна. | 100% | Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, үр дүн гарсан. | НБТСГ |
| 2 | | 3.5.2. Дүүрэг, хороод болон шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд биеийн тамир, спортын барилга байгууламжийг норм, стандартын дагуу барьж байгуулсан байна. | 2021 - 2025 | Улсын төсвөөс 17,803,000 ,000 | Улсын төсвөөс 17,802,700,000 | Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмж 62 мкв, спортын талбай 104 болсон. | Стандарт шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын талбайг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд 7 спортын байгуулсан бол 1 сургуулийн гадна талбайг иж бүрэн шинэлчилсэн.<br>2022 онд 1 спортын талбай байгуулагдсан бол 3 сургуулиудын гаднах талбайг спортын төрөлжсөн талбай болгон тохижуулсан.<br>2023 онд 37 спортын талбай байгуулагдаж 2 сургуулийн спорт талбайг хөл бөмбөгийн стандарт хиймэл зүлэг тавьж шинэчлэн тохижуулж дуусгасан.<br>Ингэснээр спортын төрөлжсөн талбайг 44-өөр нэмэгдүүлж 141 болгосон. Мөн 6 сургуулийн спортын талбайг иж бүрэн шинэчилсэн байна.<br>Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэн 2021 онд 6 2022 онд 4, 2023 онд 6 спортын барилга байгууламжийг ашиглалтад оруулсан.<br>Улсын төсвөөр баригдаж байгаа Налайх дүүргийн спорт цогцолбор 95 хувьтай, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор 85 хувьтай, Сүхбаатар дүүргийн спорт цогцолбор 40 хувьтай, Нийслэлийн Спорт цогцолбор 50 хувьтай, Багахангай дүүргийн спорт цогцолбор 60 хувьтай, Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 50 хувьтай үргэлжилж байна. Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмж 2019 онд 60 мкв байсан бол 2023 онд 3.5 мкв-аар нэмэгдүүлж 63.5 мкв болсон. | 100% | Зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн. | НБТСГ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | | 3.5.3. Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар оролцоог нэмэгдүүлсэн байна. | 2021 - 2025 | Улсын төсөөс 106,430,782 Нийслэ-лийн төсөөс 1,170,000,000 | Улсын төсөөс 106,430,782 Нийслэлийн төсөөс 1,164,571,000 | 830080 | Олон нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээнд өргөнөөр хамруулах зорилгоор 2021 онд Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтаас шалтгаалан 6 арга хэмжээ, 13 удаагийн цахим сугалтыг зохион байгуулж 89,449 иргэнд хүргэж ажилласан бол нийслэл дүүргийн хэмжээнд 116 арга хэмжээг цахим болон практик хэлбэрээр зохион байгуулж 2876 байгууллагын 635.486 иргэнийг хамруулсан.<br>2022 онд 14 арга хэмжээ зохион байгуулж 9407 байгууллагын 423,511 иргэнийг хамруулсан.<br>2023 онд нийтийг хамарсан 368 арга хэмжээнд 9930 байгууллагын 873,313 иргэдийг хамруулсан.<br>Үр дүн: Нийслэлийн иргэдийн дунд нийтийг хамарсан арга хэмжээ, ажил үйлчилгээнд 2019 онд 756,451 иргэдийг хамруулж байсан бол 2023 онд нийслэлийн хэмжээнд 368 арга хэмжээнд 9930 байгууллагын 873,313 иргэдийг хамруулж хамрагдагчдын тоог 116,862-оор нэмэгдүүлсэн байна. | 100% | Зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн. | НБТСГ |
| 4 | | 3.5.4. Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэдэг болсон байна. | 2021 - 2025 | Улсын төсөөс 146,782,300 Нийслэ-лийн төсөөс 270,000,000 | Улсын төсөөс 145,831,300 Нийслэ-лийн төсөөс 262,091,000 | 24 | Спортын тэмцээн уралдааныг 2021 онд нийт 23 удаа зохион байгуулж 518 байгууллагын 27419 хүнийг, 2022 онд 19 төрлөөр зохион баигуулж 804 байгууллагын 133102 тамирчдыг, 2023 онд 38 төрлөөр зохион байгуулж 673 байгууллагын 153317 тамирчдыг оролцуулсан байна.<br>Дүүргийн Засаг даргын дэргэдэх спортын шигшээ багийн төрөлд: 2021 онд спортын 24 төрлөөр 82 дасгалжуулагч, 1814 тамирчин хамрагдсан. 2022 онд спортын 3 төрөл (крикет, хоккей, усан спорт)-өөр нэмэгдүүлж 25 төрлөөр 65 багт 101 дасгалжуулагч, 2856 тамирчин хамрагдсан. 2023 онд 9 дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг спортын 28 төрлөөр 105 дасгалжуулагч 2944 тамирчдын бүрэлдэхүүнтэйгээр бэлтгэл, сургуулилт, дасгалжуулалтад хамруулсан. Өсвөрийн шигшээ багийн тамирчид тив, дэлхий, олон улс, хот, нэрэмжит 484 тэмцээнд оролцож 1833 медаль хүртсэн амжилт гаргасан байна. | 100% | Зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн. | НБТСГ |
| 5 | | 3.5.5. Нийслэл Улаанбаатар хотноо олон улсын спортын наадмыг зохион байгуулж дэлхийд сурталчлан, таниулах ажлыг шат дараатай зохион байгуулсан байна. | 2021 - 2025 | Улс, нийслэл, бусад 18,000,0 | Улсын төсөв 10,600.0 Нийслэ-лийн төсөв 6,800.0 | 1 | "Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа 11 спортын 12 төрлөөр 2023 оны 08 дугаар сарын 16-наас 23-ны өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулсан.<br>Тус наадмын бэлтгэл ажлын 30%-ийг 2021 онд, 70 хувийг 2022 онд, 2023 онд 100% хангаж ажилласан. | 100% | Зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн. | НБТСГ |
| ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ | | | | | | | | 100% буюу "үр дүнтэй" | | |

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБОЛД

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ОЮУНТУЯА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.БЯМБАСАЙХАН

"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"
дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн
2021, 2022, 2023 оны хэрэгжилт

2023 оны 12 дугаар сарын 27 Улаанбаатар хот

3.5.1.Нийслэлийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний чанар сайжирсан байна.

Шалгуур үзүүлэлт-1. Биеийн тамирын арга зүйч: (Зураг байхгүй)

Шалгуур үзүүлэлт-2. Магадлан итгэмжлэгдсэн спорт клуб:

Зураг-1. Хан-Уул дүүргийн 3-р хороонд байрлах “Соёл” фитнес клуб




Шалгуур үзүүлэлт-3. Иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг Нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулж 2023 оны жилийн эцсийн байдлаар 175,500 иргэн хамрагдлаа. Сорилд хамрагдсан хүмүүсийн 26 % нь - “A”, 31 % нь - “B”, 25 % нь - “C”, 12 % нь - “D”, 6 % нь - “F” үнэлгээ авсан байна.

Хүснэг-1.Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн авсан үнэлгээ (дүүргээр)

| № | Дүүрэг | Сорилд хамрагдсан хүний тоо | A үнэлгээ | B үнэлгээ | C үнэлгээ | D үнэлгээ | F үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | БХД | 1091 | 655 | 246 | 99 | 68 | 23 |
| 2 | БНД | 9783 | 1983 | 2658 | 1867 | 2382 | 893 |
| 3 | БГД | 33459 | 5513 | 10970 | 5200 | 6200 | 5576 |
| 4 | БЗД | 38167 | 11314 | 11508 | 7782 | 5259 | 2304 |
| 5 | СБД | 12851 | 4174 | 4431 | 3317 | 870 | 59 |
| 6 | СХД | 20363 | 1747 | 4127 | 12507 | 1562 | 420 |
| 7 | ХУД | 1774 | 253 | 467 | 513 | 432 | 109 |
| 8 | ЧД | 17682 | 5463 | 8956 | 2955 | 308 | 0 |
| 9 | НД | 13530 | 4022 | 4186 | 3509 | 1209 | *604* |
| Нийт дүн | | 175,500 | 35124 | 47549 | 37749 | 18290 | 9988 |
| Хувь | | 100% | 26% | 31% | 25% | 12% | 6% |

3.5.2.Дүүрэг, хороод болон шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд биеийн тамир, спортын барилга байгууламжийг норм, стандартын дагуу барьж байгуулсан байна.

Шалгуур үзүүлэлт-4. Төрөлжсөн спортын талбай:

Сагсан бөмбөгийн 3х3 талбай 2023 онд 37 байршилд байгуулагдаж нийт 141 талбайтай болоод байна.

Зураг-2.Сонгинохайрхан дүүргийн 7-р хороонд 3х3 сагсан бөмбөгийн талбай




Шалгуур үзүүлэлт-5. Спортын барилга байгууламжийн хүртээмж

Нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2019 онд 60 мкв байсан бол 2023 онд 63,5 мкв болсон.

Зураг-3.Баянгол дүүргийн 15-р хороонд баригдсан спорт цогцолбор:



Зураг-4.Хан-Уул дүүргийн 8-р хорооны битүү дээвэртэй өвлийн спортын ордон:



3.5.3.Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар оролцоог нэмэгдүүлсэн байна.

Шалгуур үзүүлэлт-6. Нийт хүн амд биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдсан иргэн

график-1




Зураг-5."Улаанбаатар марафон 2023" олон улсын гүйлт: Д.Сүхбаатарын талбайд:



3.5.4.Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэдэг болсон байна.

Шалгуур үзүүлэлт-7. Тэмцээнд оролцсон тамирчид:

Спортын тэмцээн уралдааныг 2023 онд 30 төрлөөр зохион байгуулж 673 байгууллагын 153317 тамирчдыг оролцуулсан байна.

Зураг-6
Улаанбаатар хотын аварга шалгаруулах
Хоккейн тэмцээн



Зураг-7
Улаанбаатар хотын аварга шалгаруулах
Виртуал дугуйн тэмцээн



Шалгуур үзүүлэлт-8. Өсвөрийн шигшээ багуудын спортын төрөл

График-2



3.5.5.Нийслэл Улаанбаатар хотноо олон улсын спортын наадмыг зохион байгуулж дэлхийд сурталчлан таниулах ажлыг шат дараатай зохион байгуулсан байна.

Шалгуур үзүүлэлт-9. Улаанбаатар хотноо зохион байгуулна.

Зураг-8.“Улаанбаатар-2023” Зүүн Азийн Залуучуудын наадмын нээлт Д.Сүхбаатарын талбайд:



ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБОЛД

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.БЯМБАСАЙХАН

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 12 сарын 28 өдөр Дугаар 23 Улаанбаатар хот

# "НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ" ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2021, 20228 2023 ОНЫ ЯВЦЫН ХЭРЭГЖИЛТ ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН ТАЙЛАН

Даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн ээлжит хурал 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 15:30 цагаас Нийслэлийн Засаг захиргааны IV байр 7 давхар 707 тоот өрөөнд болж Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд удирдан явуулав.

Хуралд дарга Ж.Ганболд, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаа, Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг, хурлын нарийн бичгээр Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан нар оролцлоо.

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн 2021, 20228 2023 оны явцын хэрэгжилтийг гаргасан тайланг хэлэлцэх.

## ХЭЛЭЛЦСЭН НЬ:

"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн 2021, 20228 2023 оны явцын хэрэгжилтийг гаргасан тайланг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Б.Оюунтуяа нар танилцуулав.

## СОНССОН НЬ:

Ж.Ганболд: Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2023 онд хэрэгжүүлэхээр туссан ажлын тайлан түүнд өгсөн үнэлгээг хэлэлцэе. Тайланг хэлтсийн дарга нар хянасан уу шууд эндээ хянахаар байна уу?

Г.Бямбасайхан: Хэлтсүүдээс нэгтгэхэд удирдлагууддаа хянуулсан хувийг авч нэгтгэсэн.

Б.Оюунтуяа: Үнэлгээгээ хэлтсийн дарга нарт танилцуулсан.

Ж.Ганболд: За тайлангаа дэлгэцэд гаргаад үнэлгээгээ давхар хэлэлцээд явъя.

Г.Бямбасайхан: "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан 1 зорилт, 5 арга хэмжээ, 9 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 2021, 20228 2023 оны явцаар гарган жилийн эцсийн байдлаар 98.6 хувьтай тайлагнасаныг танилцуулж байна.

Ж.Ганболд: Бид Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг өмнө нь хэлэлцсэн тул түүнд тусгагдаагүй гол гол заалтуудын үнэлгээ дээр санал, хүсэлтээ илэрхийлээд уялдуулаад явъя.

Г.Бямбасайхан: Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг уялдуулан тайлагнасан. "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг нь зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт болон хүрсэн үр дүнгийн талаар тайлагнадаг учир арга хэмжээнүүдийг нэгтгэж тайлагнасан.

Ж.Ганболд: Энэ спортын барилга байгууламжийн хүртээмжийг хэрхэн гаргасан талаар тайлбар өгнө үү.

Г.Бямбасайхан: Улирал бүр шинээр баригдаж байгаа спортын барилга, байгууламж, спортын төрөлжсөн талбайн гүйцэтгэлийн талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл авч бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан биелэлтийг гаргаж өгдөг. Мөн жилийн сүүлийн улиралд дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодоос заал талбайн судалгааг авч нэгтгэн спортын барилга байгууламжийн хүртээмжийг "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм, БНбД 30-01-04-ийн дагуу спортын заалны шалны талбайн хэмээг 1000 хүнд харьцуулан хүртээмжийг тооцоолж гаргасан. Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмж 2019 онд 60 мкв байсан бол 2023 онд 3.5 мкв-аар нэмэгдүүлж 63.5 мкв болж өссөн. Энэ нь шалгуур үзүүлэлтийнхээ 2023 онд хүрэх түвшинд бүрэн хүрсэн.

Б.Оюунтуяа: "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан 1 зорилт, 5 арга хэмжээ, 9 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 2021, 20228 2023 оны явцаар гарган жилийн эцсийн байдлаар 98.6 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн гэж үнэлсэн.

За өөр хэрэгжилтийн хувьд өөрчлөлт оруулах санал байна уу?

Нэмж тусгах санал гарсангүй.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн 2021, 20228 2023 оны явцын хэрэгжилтийг гаргасан тайланг 98,6 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн гэж тайлагнахаар шийдвэрлэлээ.

2.Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг тодорхойлж бичсэн үг, өгүүлбэрийн утга найруулгыг дахиж нягтлахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Б.Оюунтуяа нарт даалгав.

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБОЛД

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

9024010070 СТС4589 9077448

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.БЯМБАСАЙХАН